



“ЦАЙРТМИНЕРАЛ” ХХК



ТӨМӨРТИЙН-ОВООНЫ ЦАЙРЫН УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Илтгэгч: “Цайртминерал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Батхүү

Улаанбаатар хот 2022 он

Агуулга

1. Төмөртийн-Овооны цайрын ордын талаар
2. “Цайртминерал” ХХК байгуулагдсан түүх
3. Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа
4. Нийгмийн хариуцлага
5. Цаашдын зорилт

Төмөртийн-Овооны цайрын ордын талаар



Төмөртийн-Овооны цайрын ордын талаар

- Ордын хайгуулыг 1974-1979 онд Монгол-Германы хамтарсан Салхитын экспедиц хийж гүйцэтгэсэн бөгөөд цайрын хүдрийн балансын нөөц 7.7 сая.тн гэж тогтоосон.



- “Цайртминерал” ХХК уурхайн ашиглалтын хайгуулыг 2012-2016 онд гүний төвшинд нарийвчлан хийж цайр 3.2 сая тонн, төмөр 3.9 сая тонн хүдрийн нөөцийг нэмж батлуулсан.

“Цайртминерал” ХХК-ийн байгуулагдсан түүх



- Монгол улсын болон БНХАУ-ын засгийн газрын дэмжлэгтэйгээр БНХАУ-ын Экспорт импортын банкнаас хөнгөлөлттэй зээлийг авч, төслийн санхүүжилтийн томоохон хэсгийг шийдвэрлэсэн.
- Монгол улсын засгийн газартай “Цайртминерал”ХХК Тогтвортой байдлын гэрээг 1998 онд байгуулан гэрээний үүргээ амжилттай биелүүлэн 2015 дуусгавар болгосон.
- Төмөртийн-Овооны цайрын уулын баяжуулах үйлдвэрийг 2005 онд ашиглалтад оруулан 17 дах жилдээ тогтвортой ажиллаж байна.

Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа

Ерөнхий мэдээлэл

- УБҮ жилд дунджаар 450 мянган.тн цайрын хүдэр боловсруулж, 50 хувийн агуулга бүхий 70-90 мянган.тн орчим цайрын баяжмал үйлдвэрлэн экспортод гаргаж байна.
- Бүтэц зохион байгуулалтын хувьд 10 хэлтэс, 4 цех, Дотоод хяналт, Улаанбаатар хот, БНХАУ дахь төлөөлөгчийн газар гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.
- “Цайртминерал” ХХК нь нийт 379 ажилтантай үүнээс Монгол-341, Хятад-38 бөгөөд Монгол ажилчдын 96 хувь нь Сүхбаатар аймгийн иргэд юм. Мөн туслан гүйцэтгэгч компанид нийт 300 орчим хүн ажиллаж байна.




Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа



Хүдрийн ил уурхай

- Ил уурхайд хүдрийг өрөмдлөг тэсэлгээ, ухаж ачих, тээвэр овоолго гэсэн процессоор бэлтгэж, баяжуулах үйлдвэрт нийлүүлж байна.
- Хүдрийн ил уурхай 4-өөс 11-р сард ажиллаж, дунджаар 450 мянган тн хүдэр олборлож, 1.2 сая шоо метр хөрс хуулалт хийдэг.

Төмөртийн-Овооны цайрын ордын нөөц



Ордын нөөц

- 2012-2016 оны хооронд ил уурхайн хүрээн дотор хийсэн гүний хайгуулын дүнд 3.2 сая тн цайрын хүдрийн нөөц нэмэгдэж, олборлолтын арга ил уурхайгаас далд уурхай руу шилжинэ.
- Нэмэгдсэн нөөцийн дүнд УБҮ 2030 он хүртэл ажиллах нөөцтэй боллоо.

Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа



Хүдрийн далд уурхай

- Далд уурхайн бэлтгэл малталт 2022 оны 1 сараас эхлэн хийгдэж байна.
- 2023 оны намраас хүдэр олборлож эхлэхээр төлөвлөж байна.
- Далд уурхайн хүчин чадал жилд 450 мянган.тн хүдэр олборлоно.

Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа


Баяжуулах үйлдвэр

- Баяжуулах үйлдвэр цайрын сульфидын хүдрийг хөвүүлэн баяжуулах технологи ашиглан БНХАУ, Швед зэрэг орны тоног төхөөрөмжөөр хүдэр бэлтгэх, нунтаглан баяжуулах, усгүйжүүлэх гэсэн дамжлагаар боловсруулж 55 хувь хүртэл агуулга бүхий цайрын баяжмал үйлдвэрлэдэг.
- Үйлдвэрийн хүчин чадал хоногт 1200 тн хүртэл цайрын хүдэр баяжуулан, 94-ээс дээш хувийн металл авалттайгаар ажиллаж байна.
- Үйлдвэрийн 2021 оны үзүүлэлт

БҮТЭЭГДЭХҮҮН	АГУУЛГА %	ГАРЦ %	МЕТАЛЛ АВАЛТ %
АНХДАГЧ ХҮДЭР	9.55	100	100
БАЯЖМАЛ	52.41	17.2	94.43
ХАЯГДАЛ	0.64	82.98	5.57



Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа



Төмөртнийн-Овооны цайрын УБҮ 2021 оны байдлаар уурхайгаас 6,753.01 мянган.тн хүдэр олборлож, баяжуулах үйлдвэрт 6,534.19 мянган.тн хүдэр боловсруулан 1,584.63 мянган.тн баяжмал үйлдвэрлэсэн.

Уулын үйлдвэрийн үйл ажиллагаа

Бүтээгдэхүүний чанар, хяналт, борлуулалт

- Сорилт шинжилгээний лаборатори нь СХЗҮТөвөөс 2007 оны 7 дугаар сард Итгэмжлэлийн гэрчилгээ авч Монгол улсын “Баяжмалын техникийн шаардлага MNS 5717:2007” мөрдөж ажиллаж байна.
- Үйлдвэр жилд 80 мянган тонн орчим цайрын баяжмалыг Монгол улсын гаалийн хяналт хийлгэн Лондоны металлын биржийн үнийг үндэслэн олон улсын баяжмалын жишиг аргачлалын дагуу тооцон экспортод гаргаж байна.



Нийгмийн хариуцлага



Байгаль орчин, нөхөн сэргээлт

Байгаль орчин хамгаалах ажлыг БОНБУ-нд тусгагдсаны дагуу жил бүр төлөвлөн гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар техникийн нөхөн сэргээлтийг 27.2 га, биологийн нөхөн сэргээлтийг 25.8 га талбайд хийж гүйцэтгэн, уурхай орчмын талбайд 14500 мод бут суулгасан. Үйлдвэрийн эргэлтийн усны 75.6%-ийг эргүүлэн ашиглаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-MNS ISO 45001:2018, олон улсын Байгаль орчны менежментийн тогтолцоо – MNS ISO 14001:2016 стандартуудыг Төмөртийн-Овооны УБҮ-т нэвтрүүлэх ажил хийгдэж байна.



Нийгмийн хариуцлага



Ажилчдын нийгмийн асуудал



Орон нутгийн залууст мэргэжил
эзэмшүүлэн ажилтан бэлтгэх



Орон сууцжуулах төсөл амжилттай
үргэлжилсээр 108 айл хамрагдсан



Өөрийн тарьсан чанартай хүнсээр
ажилчдаа хангадаг



Уурхайчдын эрүүл мэндийг
хамгаалах төсөл



Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт 564
залуус хамрагдсан



Ажиллах таатай орчинг
бүрдүүлсээр байна

Нийгмийн хариуцлага




Орон нутагтай хамтын ажиллагааны гэрээг 2013 онд байгуулсан анхдагч аж ахуй нэгж болсон бол 2021 онд Засгийн газрын 179 тогтоолын дагуу Сүхбаатар аймагтай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулан гэрээний дагуу эрүүл мэнд, боловсрол, жижиг дунд бизнес дэмжих, бүтээн байгуулалтын тодорхой төсөл хөтөлбөрт зориулан жил бүр 1.8 тэрбум төгрөгийн хандив, санхүүжилтийг хийж байна. Өнгөрсөн хугацаанд орон нутгийн тулгамдсан асуудлууд, бүтээн байгуулалт, эрүүл мэндийн салбар, жижиг дунд бизнесийн салбар зэрэгт нийтдээ 24.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.



Эдийн засгийн үзүүлэлт



Улс, орон нутагт нийтдээ 599.2 тэрбум төгрөг



“Цайртминерал” компани Монгол Улсын Засгийн газарт 2005 - 2021 оны байдлаар 599.2 тэрбум төгрөгийг татвар, хураамж болон бусад төлбөрт, үүний дотор 20.1 тэрбум төгрөгийг харилцагчдын НӨАТ*-д, орон нутагт 52.1 тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлсэн. “Цайртминерал” ХХК НӨАТ-ын буцаан авалтад хамрагддаггүй.

Нийгмийн хариуцлага



Цаашдын зорилт

- Төмөртийн-Овооны уулын үйлдвэр суурилагдсан хүч чадлаа тогтмол барьж 2030 он хүртэл ажиллах баталгаат нөөцтэй.
- Хүдрийн нөөц өсгөх зорилготой үйлдвэрийн орчимд 2 талбайд геологи хайгуулын ажлыг идэвхтэй явуулж байгаа бөгөөд нөөц өсөх боломжтой юм.
- Баяжуулах үйлдвэрийн хаягдалд агуулагдаж буй төмрийг баяжуулан экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэхээр төсөл судалгааны ажил хийгдэж байна.
- Цар тахлаас шалтгаалан бүтээгдэхүүн экспорт ихээхэн саатаж байгаа тул цаашид жигд тогтвортой ажиллагааг хангах зорилгоор экспортын гарц боомтыг нэмэгдүүлэх зорилт тулгарч байна.



Анхаарал тавьсан та
бүхэнд баярлалаа